



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/43

Дуурсах

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.5 дахь заалт, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалт, Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны 05 сарын 23 өдрийн А/349 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулсугай.

2. Үйл ажиллагааны удирдамжийг нэгдүгээр, зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Үйл ажиллагаанд шаардагдах 499.800 (дөрвөн зуун ерэн есөн мянга найман зуун төгрөг)-ийг бараа үйлчилгээний бусад зардлаас гаргахыг ерөнхий нягтлан бодогч (П.Мөнх-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

4. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн үйл ажиллагааг захирамж, удирдамжийн дагуу үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн боловсрол, эрүүл мэндийг дэмжих асуудал хариуцсан мэргэжилтэн (А.Ууганцэцэг)-т үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга (Т.Хажидсүрэн)-д даалгасугай.



ДАРГА *Хажидсүрэн* ЭНХЖАРГАЛ

2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн  
143 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг  
тэмдэглэн өнгөрүүлэх “Эрүүл мэнд -Эрхэм баян”  
өртөө гаргах ажлын удирдамж

**Нэг. Үндэслэл**

Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 оны 05 сарын 23-ны өдрийн “Нэгдүгээрт хүүхэд” уриан дор Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай А/349 дүгээр захирамж, Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2022 оны 05 сарын 24-ний өдрийн “Хамтран ажиллах тухай” 259 дүгээр албан бичгийн дагуу “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”- ийг байгууллага, хамт олноор идэвхтэй үр дүнтэй тэмдэглэн өнгөрүүлэх.

**Хоёр. Зорилго**

Эрүүл мэндийн чиглэлээрх дасгал хөдөлгөөний ач холбогдлыг сурталчилах, эцэг, эх асран хамгаалагч, олон нийтийн эрүүл мэндийн талаарх үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх.

**Гурав. Зорилт**

Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд эцэг эхчүүд, хүүхэд, залууст эрүүл мэндийн сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажил зохион байгуулах.

**Хоёр. Хамрах хүрээ**

Баянхонгор аймгийн 0-17 насны хүүхэдтэй гэр бүл, үйл ажиллагаанд оролцогчид.

**Гурав. Үйл ажиллагаа**

Хөдөлгөөн-Эрүүл мэнд хөгжөөнт тэмцээн

Эрүүл мэндийн мэдээлэл, сурталчилгаа

“Эрүүл мэнд-Эрхэм” баян сэдэвт танин мэдэхүйн АХА тэмцээн

Баянхонгор сумын 10 хүүхдэд гарын бэлэг гардуулах үйл ажиллагаа

**Дөрөв. Хугацаа, зохион байгуулах газар**

2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн 11:00-15:00 цагт аймгийн Баганат талбай

**Тав. Үр дүн**

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд “Эрүүл мэнд-Эрхэм баян” өртөөг үр дүнтэй ажиллуулж хүүхэд багачууд, эцэг эх асран хамгаалагч, олон нийтэд эрүүл мэнд дасгал хөдөлгөөний ач холбогдлыг сурталчлан таниулсан байна.

2022 оны 05 дугаар сарын 20 ны өдрийн  
№3 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДРИЙГ  
ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ "ЭРҮҮЛ МЭНД-ЭРХЭМ БАЯН"  
ӨРТӨӨНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	2	3	4	5	6
1.	Сургалт мэдээллийн гарын авлага, брошур	ш	500	700	350000
2.	Тэмцээн зохион байгуулах бичиг хэрэг, хэрэглэгдэхүүний зардал	ш	10	9000	90000
	Өртөөний хаяг	ш	1	19800	19800
	Баярын баннер( хулдаасан хэвлэл)	ш	1	40000	40000
<b>Дүн</b>					<b>499800</b>

\_\_\_оОо\_\_\_